



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агро-сити эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/365/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 327734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Баасанням Утас: 325093 Цахим хаяг: baasannyamd@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 02. 25 № 316
танай _____-ны № _____-т

АГРО-СИТИ ЭДИЙН ЗАСГИЙН
ТУСГАЙ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ЗАХИРАГЧ
Г.БАТБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Агро-сити эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Монгол улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 220 дугаар тогтоолоор Агро-сити эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын алба үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай программ хангамжийн лицензийн төлбөрт 189.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудал

1426050555

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	18,254,081.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	18,254,081.00
354	Хангамжийн материал	0.00	18,254,081.00
35410	Бичиг хэргийн материал		5,782,611.00
35420	Аж ахуйн материал		7,803,470.00
35440	Түлш, шатах тослох материал		4,668,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	305,769,434.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	305,769,434.19
392	Биет хөрөнгө	0.00	144,583,578.19
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		101,000,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(10,520,833.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		47,600,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		-1,586,666.48
39214	Бусад үндсэн хөрөнгө		10,287,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(2,196,322.33)
393	Биет бус хөрөнгө	0.00	161,185,856.00
39301	Програм хангамж		192,670,656.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(31,484,800.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	324,023,515.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	324,023,515.19
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	324,023,515.19
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	324,023,515.19
51220	Тайлант үеийн үр дүн		324,023,515.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	324,023,515.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	0.0	1,057,103,323.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.0	1,057,103,323.93
122	Тусламжийн орлого	0.0	1,057,103,323.93
1221	Хандив тусламж /дотоод/	0.0	1,057,103,323.93
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	1,057,103,323.93
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	1,057,103,323.93
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.0	733,079,808.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.0	733,079,808.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.0	726,839,808.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	279,892,178.44
210101	Үндсэн цалин	0.0	152,888,054.09

**Агро сити эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210102	Нэмэгдэл	0.0	29,614,737.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	59,232,061.75
210104	Урамшуулал	0.0	4,752,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	33,405,324.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	34,528,569.63
210201	Тэтгэврийн даатгалын зардал	0.0	23,605,961.06
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	0.0	2,810,866.94
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	0.0	1,290,723.92
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	0.0	1,266,673.92
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	0.0	5,554,343.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	130,982,586.70
210301	Гэрэл, цахилгаан	0.0	1,205,257.08
210302	Түлш, халаалт	0.0	354,677.59
210303	Цэвэр, бохир ус	0.0	348,634.03
210304	Байрны түрээс	0.0	129,074,018.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.0	17,402,722.90
210401	Бичиг хэрэг	0.0	633,550.00
210402	Тээвэр, шатахуун	0.0	8,547,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.0	7,021,612.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.0	1,200,380.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	59,726,497.00
210604	Урсгал засвар	0.0	59,726,497.0
2107	Томилолт, зочны зардал	0.0	8,500,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.0	8,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.0	147,520,632.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	147,328,852.26
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.0	191,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	48,286,621.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.0	2,498,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.0	45,788,621.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	6,240,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	6,240,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	6,240,000.00
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0.0	324,023,515.19
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		324,023,515.19

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	1,057,103,323.93
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1,057,103,323.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	1,057,103,323.93

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,057,103,323.93
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	905,203,323.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	905,203,323.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	898,963,323.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	279,892,178.44
210101	Үндсэн цалин		148,049,485.56
210102	Нэмэгдэл		29,812,184.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт		61,012,381.75
210104	Урамшуулал		4,752,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		36,266,126.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	34,528,569.63
210201	Тэтгэврийн даатгал		23,605,961.06
210202	Тэтгэмжийн даатгал		2,810,866.94
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,290,723.92
210204	Ажилгүйдлийн даатгал		1,266,673.92
210205	Эрүүл мэндийн даатгал		5,554,343.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	130,982,586.70
210301	Гэрэл, цахилгаан		1,205,257.08
210302	Түлш, халаалт		354,677.59
210303	Цэвэр, бохир ус		348,634.03
210304	Байрны түрээс		129,074,018.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	45,944,203.90
210401	Бичиг хэрэг		6,416,161.00
210402	Тээвэр, шатахуун		13,215,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		7,021,612.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		19,291,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	59,726,497.00
210604	Урсгал засвар		59,726,497.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	8,500,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		8,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	336,891,288.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		147,328,852.26
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		189,370,656.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		191,780.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,498,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,498,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	6,240,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	6,240,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,240,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	151,900,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	151,900,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	151,900,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	151,900,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		151,900,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	(151,900,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	324,023,515.19		324,023,515.19
C08	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			324,023,515.19		324,023,515.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,441,011,300	1,057,103,323.93	383,907,976.07	73.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,441,011,300	1,057,103,323.93	383,907,976.07	73.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,426,511,300	1,050,863,323.93	375,647,976.07	73.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,167,400	279,892,178.44	122,275,221.56	69.6
210101	Үндсэн цалин	200,760,000	148,049,485.56	52,710,514.44	73.7
210102	Нэмэгдэл	6,307,400	29,812,184.78	(23,504,784.78)	472.7

Агро сити эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,700,000	61,012,381.75	23,687,618.25	72.0
210104	Урамшуулал	33,460,000	4,752,000	28,708,000.00	14.2
210105	Гэрээт ажлын хөлс	76,940,000	36,266,126.35	40,673,873.65	47.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,314,300	34,528,569.63	23,785,730.37	59.2
210201	Тэтгэврийн даатгал	34,184,300	23,605,961.06	10,578,338.94	69.1
210202	Тэтгэмжийн даатгал	4,021,700	2,810,866.94	1,210,833.06	69.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,260,700	1,290,723.92	9,969,976.08	11.5
210204	Ажилгүйдлийн даатгал	804,300	1,266,673.92	(462,373.92)	157.5
210205	Эрүүл мэндийн даатгал	8,043,300	5,554,343.79	2,488,956.21	69.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,400,000	130,982,586.7	18,417,413.30	87.7
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000	1,205,257.08	794,742.92	60.3
210302	Түлш, халаалт	1,500,000	354,677.59	1,145,322.41	23.6
210303	Цэвэр, бохир ус	1,000,000	348,634.03	651,365.97	34.9
210304	Байрны түрээс	144,900,000	129,074,018	15,825,982.00	89.1
2104	Хангамж, бараа материалын зардал	53,304,000	45,944,203.9	7,359,796.10	86.2
210401	Бичиг хэрэг	14,005,000	6,416,161	7,588,839.00	45.8
210402	Тээвэр, шатахуун	5,280,000	13,215,180	(7,935,180.00)	250.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,300,000	7,021,612.9	7,278,387.10	49.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,719,000	19,291,250	427,750.00	97.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	274,826,200	208,326,497	66,499,703.00	75.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	148,535,200	101,000,000	47,535,200.00	68.0
210602	Тавилга	57,331,000	47,600,000	9,731,000.00	83.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,960,000	0.0	8,960,000.00	0.0
210604	Урсгал засвар	60,000,000	59,726,497	273,503.00	99.5
2107	Томилолт, зочны зардал	22,000,000	8,500,000	13,500,000.00	38.6
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	22,000,000	8,500,000	13,500,000.00	38.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	415,499,400	340,191,288.26	75,308,111.74	81.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	188,300,000	147,328,852.26	40,971,147.74	78.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000	0.0	7,000,000.00	0.0

210803	Даатгалын үйлчилгээ	296,500	0.0	296,500.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	169,900	0.0	169,900.00	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	400,000	0.0	400,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	211,833,000	192,670,656	19,162,344.00	91.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,500,000	0.0	2,500,000.00	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,000,000	191,780	4,808,220.00	3.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,000,000	2,498,000	48,502,000.00	4.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,000,000	2,498,000	48,502,000.00	4.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,500,000	6,240,000	8,260,000.00	43.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,500,000	6,240,000	8,260,000.00	43.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,500,000	6,240,000	8,260,000.00	73.4
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	0	0		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	0		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	0	0		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	21	0.0		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	0.0		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	10	0.0		
620001	Удирдах ажилтан	1	0.0		
620002	Гүйцэтгэх ажилтан	9	0.0		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	10	0.0		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	0.0		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 10,287.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн дансанд 10,287.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй байна.

Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 11,416.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 6,029.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 5,387.8 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо нэмэгдэл хөлс олгох журмыг баримтлаагүй 6,029.0 төгрөгийг хавтгайруулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан *"Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох журам"*-ын 2 дугаар хавсралтын 3-д *"Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагын дотоод журмаар тогтоосон өдрийн ажлын цагийг ажил олгогчийн санаачилгаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажиллуулсанд, орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацаанд ажиллуулахыг шөнийн цагаар ажиллуулсанд, нийтээр амрах баярын өдрүүдэд ажиллуулахыг нийтээр амрах баярын өдөр ажиллуулсанд, Бямба, Ням гарагт ажиллуулахыг долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулсанд тус тус тооцож, нөхөн амруулаагүй тохиолдолд нэмэгдэл хөлс олгоно"* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн нэмэгдэл хөлс олгох журмыг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бүрдэл дутуу анхан шатны баримтаар 5,387.8 мянган төгрөгийн гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан. Энэ нь УСНББОУС-30 *"Санхүүгийн хэрэглүүр, тодруулга"* болон MNS-6817-4-2020 стандартын 5.2.1.7.4 *"Голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*, 20 дугаар зүйлийн 20.1.4-т *"хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийн шаардлага хангасан ажил гүйлгээг данс бүртгэлд тусгаж байх.

2. Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт: Бараа материалын орлого, зарлагын тайланг бэлтгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.3 жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4 үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг тухай бүр нь үнэн зөв хөтөлж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн дансанд 10,287.4 төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй байна	1	10,287.4			1	10,287.4	1	10,287.4		
Дүн	1	10,287.4			1	10,287.4	1	10,287.4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо нэмэгдэл хөлс олгох журмыг баримтлаагүй төгрөгийг хавтгайруулан олгосон байна	1	6,029.0			1	6,029.0		
Бүрдэл дутуу анхан шатны баримтаар 5,387.8 мянган төгрөгийн гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан.	1	5,387.8					1	5,387.8
Бараа материалын орлого, зарлагын тайланг бэлтгээгүй байна.	1						1	-
Дүн	3	11,416.8			1	6,029.0	2	5,387.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,382,962.1 мянган төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй, 24 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	1,382,962.1					1	1,382,962.1
Байгууллагын ажилтнуудыг Нура төвд урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, төлбөрийг төсвөөс төлсөн байна	1	6,240.0					1	6,240.0
Дүн	2	1,389,202.1					2	1,389,202.1

**5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА
САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллагын тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
	Нийт	1	1			1			